

МОНГОЛ МАЛЧИН

НҮҮХҮҮ ҮЛДЭХҮҮ



"МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН
ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУИ
БОЛГОХ НЬ" (АДАЛТ) ТӨСӨЛ

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ МАЛЧИЙН

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Уур амьсгалын өөрчлөлт гэж агаарын температур болон цаг агаарын төлөв байдал урт хугацаанд өөрчлөгдөхийг хэлнэ.

1800 ОНООС ХОЙШ

МАНАЙ ОРОНД:



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНД ДАСАН ЗОХИЦОХ АРГА ХЭМЖЭЭ



Уур амьсгалын өөрчлөлтөд малчид дасан зохицож бэлчээрийг зүй зохистой ашиглан, бэлчээрийн даацад нийцүүлэн мал аж ахуйгаа эрхлэх нь чухал юм.

БЭЛЧЭЭРИЙН АЛТАН ДҮРЭМ

- 1 Бэлчээрийн даацыг үл хэтрүүлэх
- 2 Тэжээлийн нөөцийг үл шавхах
- 3 Бэлчээрийн ургамалд төлжин ургах боломж олгох
- 4 Бэлчээрээ сэлгэж байх зэрэг болно



ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИН

**"ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИН ЗОХИСТОЙ ДАДЛЫГ
НЭВТРҮҮЛЭХЭД ТАВИХ ШААРДЛАГУУД" СТАНДАРТ:**

Мал, амьтны тавлаг байдлын таван эрх чөлөөг хангах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэгчийн түвшинд хариуцлагатай нүүдэлчин тогтолцоог хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлага, шалгууруудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулахад оршино.

**"ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН"-ГИЙН ЭХ ҮҮСВЭРТ МАЛЫН ТОО ТОЛГОЙН
АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫГ ТУСГАСАН. ТУС ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ:**



Бэлчээрийн
монокультуртэйг
сайжруулах



Малын
чанарыг
сайжруулах



Бэлчээрийн усан
хангамжийг
нэмэгдүүлэх



Малын тэжээлийн ургамал
тариалах, тэжээлийн ноёд
бурдуулах, байгаль орчныг
хамгаалах гэх мэт арга хэмжээг
хэрэгжүүлэхэд зориулна



Малын эрүүл
мэндийг хамгаалах,
калдварт өвчнөөс
урьдчилан
сэргийлэх

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ЗОХИЦСОН МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН



Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон, гарал үүсэл нь тодорхой мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, нэмүү өртгийн үйлдвэрлэлд төр, хувийн хэвшил, нөхөрлөлийн түншлэлийг бий болгоход "Хариуцлагатай нүүдэлчин" стандартыг мөрдөх нь чухал юм.

**"ХАРИУЦЛАГАТАЙ
НҮҮДЭЛЧИН" СТАНДАРТАД
ДАРААХ ҮНДСЭН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ ХАМААРНА.**



1 Малын бэлчээр



2 Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекц



3 Малын эрүүл мэнд



4 Малын тэжээллэг, арчилгаа, маллагаа



5 Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт



МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ* (АДАПТ) ТӨСӨЛ



АДАПТ ТӨСӨЛ



INFO@GCF-RURAL.MN



976 - 75057507



WWW.GCF-RURAL.MN

ДУГААРЫН ХӨТӨЧ



14

АДАПТ

“АДАПТ” ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ
800,000 МАЛЧИН ӨРХ ХҮРТЭНЭ

АДАПТ төсөл “Дорнод аймгийн малчдын зөвлөгөөн” 2022 он

ТӨРИЙН БОДЛОГО

Т.Жамбалцэрэн:

Монгол орны нийт нутгийн 70 орчим хувь нь
зудын эрсдэлтэй байна

6

ЗАЛУУ МАЛЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Өөртөө болон гэр бүлдээ анхаарал тавьж,
эрүүл мэндээ хамгаалаарай...

8

ДУГААРЫН ЗОЧИН

М.Ганбаатар:

Цөөн тооны чанартай малтай байх нь уур амьсгалын
өөрчлөлтийг сааруулахад чухал нөлөөтэй

10

АДАПТ

Нүүх үү, үлдэх үү?

18

Ховд аймаг

18

Сүхбаатар аймаг

19

Завхан аймаг

20

Дорнод аймаг

21

ЗУДЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ

Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан
урьдчилсан мэдээ

22

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж, хөгжсөний түүхт
100 жилийн ойн арга хэмжээнээс...

29

Түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд
оролцогчдын сэтгэгдлээс...

30

БИОКОМБИНАТ ТӨХХК

Биокомбинат ТӨХХК-ийн 2023 онд хийсэн
онцлох ажлууд

36

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

39

Технологи дамжуулах чиглэлээр

39

ЭХ ОРНЫ ЭДИЙН ЗАСАГ

Уур амьсгалын өөрчлөлт ба эрчим хүч

40

Эрчим хүчний ирээдүй

42

Зөөвч-Овоо төслийн боломж

43

Чухам яаж хувь нэмрээ оруулах вэ?

43

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО

Хэнтий аймагт “Хоршоололд залуусын оролцоо”
сэдэвт уулзалт зохион байгуулагдлаа

44

“Баруун бүсийн үйлдвэржилт ба хоршоод”

45

зөвлөгөөн боллоо

45

ХӨРӨГ

Монгол Улсын аварга Чимэдрэгзэнгийн Санжаадамба

48

ХОНИНЫ ЭЭЛЖ

Ижий танаа

50

Тэнгэр ээж минь өршөө

51

Редакцийн зурвас

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ:

О.ӨЛЗИЙБАДРАХ

80111143

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Н.НОРОВ

Нийтлэлийн бодлогын дарга

Д.ТУЯАДЭЛГЭР

Удирдах зөвлөлийн гишүүн, судалгаа
шинжилгээний ажилтан

Д.САМДАНЖАМЦ

Монгол Улсын зөвлөх, гавьяат малзүйч

Д.РИНЧИНДОРЖ

ХААУ-ы доктор, дэд профессор, МУ-ын
зөвлөх малзүйч

Я.ГАНБОЛД

Академич, Мал эмнэлгийн ШУ-ы
доктор, профессор

Б.МИНЖИГДОРЖ

Монгол Улсын зөвлөх, Гавьяат
мал зүйч, доктор, профессор

Д.ГҮРБАЗАР

ХААУ-ы доктор, МУ-ын тэргүүлэх
малзүйч

Б.ДОВДОНБАЛЖИР

Эдийн засгийн ухааны доктор

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

С.МӨНХЖАРГАЛ

СЭТГҮҮЛЧ:

С.МӨНХЖАРГАЛ

М.АРИУНЖАРГАЛ

М.ДЭЛЭГ

ДИЗАЙНЕР:

Н.БЯМБАЦОГТ

Сэтгүүлийн хаяг:

Монгол Улс, УБ хот Баянзүрх дүүрэг
МХААХҮХ-ны төв байр 508 тоот

Захиалга авах данс:

ТӨРИЙН банк: 101400210861

Утас: 7739 7737

Сайт: www.mongolmalchin.mn

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу
хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн
хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон
системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр
олшруулахыг хориглоно.

Эрхэм захиалагч

.....танд

Алтан дэлхий цасан цагаан нөмөргөө өмссөн, өвлийн дунд хөх хулгана сард “МОНГОЛ МАЛЧИН” сэтгүүлийнхээ 92 дахь дугаарыг эх орныхоо өнцөг булан бүрт суугаа малчин түмэндээ болон мал аж ахуйн салбарт ажиллагсдадаа өргөн барьж байна.

Энэ удаагийнхаа дугаарт жил ирэх тусам хувьсан эрсдэл дагуулж буй уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээрийн доройтол, түүний үр нөлөө, хор хохирлыг хамгийн их амсаж буй малчин түмний асуудлыг хөндлөө. Өнөөгийн мал аж ахуйн салбарын амин чухал асуудал болсон сэдвээр бэлтгэсэн энэхүү дугаарыг маань “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсонгоо болгох нь”(АДАПТ) төслөөс дэмжин, хамтран ажиллалаа.

Дугаарын зочноор Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд, “АДАПТ” төслийн удирдах хорооны дарга М.Ганбаатарыг урьж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, зудын эрсдэл, бэлчээрийн асуудлаар ярилцсан бол “Төрийн бодлого” буландаа ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, төслийн удирдах хорооны дэд дарга Т.Жамбалцэрэнг урьж, ярилцлаа.

Мөн энэхүү дугаартаа “АДАПТ” төслийн үр дүнд бий болж байгаа эерэг өөрчлөлт, бодит сайн жишиг, туршлагауд, үр шимийг хүртэж буй малчдыг онцолсон бол “Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж, хөгжсөний түүхт 100 жилийн ой”-н хүндэтгэлийн арга хэмжээнээс “Дугаарын сурвалжилга”-аа бэлтгэлээ. Тэгвэл “Залуу малчдад өгөх зөвлөмж”-өө мал сүргээ онд мөнд оруулж, өвлийн хүйтнийг ажралгүй даван туулах арга замын талаар салбарын мэргэжилтнүүд, туршлагатай ахмад ажилтан, малчидтай хамтран хүргэж байна.

Монгол орны нийт нутгийн 70 орчим хувь нь зудын эрсдэлтэй байгаа энэ онцгой хүнд цаг үед “АДАПТ” төсөл, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнтэй хамтран хийсэн зудын эрсдэлийн судалгаа, түүнд үндэслэн гаргасан урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх зөвлөмж мэдээллийг малчдадаа хүргэхээр онцлон нийтэллээ.

Эрхэм уншигч та бүхэн энэхүү дугаараас хөдөө аж ахуйн салбарын хамгийн сүүлийн үеийн цогц мэдээлэл, төрөөс баримталж байгаа бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, бэлчээр, цөлжилтийн нөхцөл байдал, судалгаа мэдээлэл, байгалийн эрсдэлийг даван туулах чадавх гээд мал аж ахуйн салбарын арвин баялаг мэдээ, мэдээллийг хүлээн авч уншин амьдрал, аж ахуйдаа хэрэгжүүлээрэй.

“МОНГОЛ МАЛЧИН”
СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ



Т.ЖАМБАЛЦЭРЭН:

МОНГОЛ ОРНЫ НИЙТ НУТГИЙН 70 ОРЧИМ ХУВЬ НЬ ЗУДЫН ЭРСДЭЛТЭЙ БАЙНА



Энэ удаагийн "ТӨРИЙН БОДЛОГО" буландаа ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнг урьж, мал аж ахуйн салбарын цаг үеийн байдал, төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, хэрэгжүүлж буй арга хэмжээ, малчдын өмнө тулгамдаж буй асуудлуудыг тодрууллаа.

- Урилгыг маань хүлээж авсан танд баярлалаа, мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаг үеийн асуудлаар ярилцлагаа эхлэх үү...

Юуны өмнө танай хамт олонд болон уншигчдадаа энэ өдрийн мэндийг хүргэе. Мал аж ахуйн салбар нь хүн амыг хүнсээр, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангадаг манай улсын тулгуур салбарын нэг юм. Манай улсын хүн амын 29.9 хувь хөдөөд амьдарч, нийт өрхийн 41.2 хувь, ажиллах хүчний 32.0 хувь нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Тус салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 85 хувийг эзэлдэг. Энэ өвөл улсын хэмжээнд нийт 70 сая орчим толгой мал өвөлжих урьдчилсан дүн гарсан. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах чиглэлээр орон нутгийн удирдлага, малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчидтэй жил бүр хамтран ажилладаг. Гэвч байгаль цаг уурын гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас мал аж ахуйн салбарт хүндрэл учрах явдал гарч байна. Хүйтний эрч эрс чангарч, хэд, хэдэн аймагт зудын эрсдэл үүсээд байгаа. Иймээс отроор нүүдэл хийж байгаа малчдын аюулгүй, ая тухтай байдлыг хангах, хүн, малын эрүүл мэндийг хамгаалах, бензин шатахууны олдцыг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн хангамжийг сайжруулах, малчид малаа зах зээлд борлуулахад

туслах ажлуудыг зохион байгуулж байгаа. Ялангуяа малчид маань цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг өдөр тутмын хэрэглээ болгож, урьдчилан сэргийлэх, цаг ямагт өөрийгөө хамгаалж дулаан хувцас, уналга, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах нь зүйтэй. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс гаргасан зудын эрсдэлийн судалгаагаар нутгийн 70 гаруй хувьд цастай, ихэнх нутгаар 5-33 см, хунгарлаж шуурсан газраа 70 см хүртэл зузаан цастай байна.

- Харин ихэнх нутгаар л өвөлжилт хүндэрчихлээ. Ер нь жил ирэх тусам байгаль, цаг уур өөрчлөгдөж, үр дүнд нь малчид л хамгийн их зүдэрч байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг яамнаас хэр авч байна вэ?

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас жил бүр 21 аймаг, 330 сумын газар, тасаг нэгжүүдтэйгээ хамтран өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулдаг. Улсын зүгээс аюулгүйн нөөцийг бүрдүүлэх чиглэлд ажилладаг. Харин мал бол хувийн өмч учраас малчид өөрсдөө бэлтгэл ажлаа хангана шүү дээ. Ер нь бэлтгэлээ хэр хангаснаас шалтгаалж байна л даа. Байгаль, цаг уурын эрсдэлийг даван туулах чиглэлд олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажилладаг. Зорилгод бүс нутаг, аймаг, сумаа сонгоод

хэрэгжүүлээд явж байна. Тухайлбал Уур амьсгалын Ногоон сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь"/АДАПТ/ төслөөс Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнтэй хамтран зудын эрсдэлийн судалгааг хийсэн байгаа. Зудын эрсдэлийн зургийг боловсруулахдаа өнгөрсөн зуны ган, зуншлага, 2023-2024 оны өвөл, хаврын бэлчээрийн даац, бэлчээрийн ургац, малын тоо, агаарын температур, хур тунадасны дундажтай харьцуулсан хазайлт, энэ жилийн цасны бүрхэц, зузаан болон тухайн сарын агаарын температур, хур тунадасны төлөв зэрэг мэдээллийг ашиглаж гаргадаг. Судалгаагаар нутгийн баруун болон өмнөд бүс нутгийн зарим хэсгээр зуны турш гандуу, гантай байдалтай байснаас гадна өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 50 гаруй хувьд ихээхэн хэтэрч гарсан. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт нутгийн 70 орчим хувьд нь зудын эрсдэл их, 20 хувьд нь дунд эрсдэлтэй байгаа бол дөнгөж 5 хувь нь бага эрсдэлтэй гэсэн судалгаа гарсан учраас малчид маань бэлтгэлээ сайтар базаах хэрэгтэй байна.

- "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж

болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь"/АДАПТ/ төслөөс бас мал аж ахуйн салбарт чамгүй үр өгөөжтэй ажлууд нэлээд хийж байх шиг байна...

Тийм. Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран Завхан, Ховд, Дорнод, Сүхбаатар аймагт хэрэгжүүлж байгаа төсөл л дөө. БОАЖ-ын дэд сайд М.Ганбаатар төслийн удирдах хорооны даргаар, миний бие дэд даргаар ажиллаж байгаа. Тус төсөлтэй хамтран 3220 га талбайд бэлчээрийн менежментийг сайжруулах, өвс тэжээлийн 48 агуулах барих, усны нөөцийн хүрэлцээг хангах зорилгоор 2500 га талбайд татмын ойжуулалт, тармаг ойн нөхөн сэргээлт, 88 булаг шандыг хашиж хамгаалах, 285 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргах, засварлах, 18 бага оврын хөв цөөрөм барих зэрэг арга хэмжээг 2022-2027 онуудад хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төслийн хүрээнд Мал аж ахуйн тогтвортой байдлыг хангах чиглэлээр баруун бүсийн Ховд, Завхан, Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар зэрэг аймгуудад 2022, 2023 онуудад шинэ худаг барьж байгуулах, бэлчээрт уст цэг тогтоох хайгуул, судалгааны ажил явуулах, булаг тохижуулах, отрын нөөц нутаг бий болгох зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. Мөн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд төр-хувийн хэвшил-малчдын түншлэлийг бий болгох, малчдын байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан борлуулах ажлыг төслийн 4 аймаг, тус бүрд 2 суманд туршиж эхэлсэн. Төсөл хэрэгжиж буй аймгуудын малчид нь тус төсөлтэй хамтарч ажилласнаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өвөл, хаврын эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах арга барил, дадал туршлагад суралцах, ялангуяа, байгалийн нөөцийг хэрхэн зөв ашиглах, хамгаалах талаар мэдлэг, туршлага эзэмших боломжтой юм.

- Нэгэнт өвөлжилт хүндрэх нь тодорхой болсон учраас малчид малаа их хэмжээгээр нядалж байна. Гэтэл мал, махны үнэ маш бага байна л даа. Энэ тал дээр танай яамнаас ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Мах бэлтгэл болон 2024 оны ноолуур, ноос, бэлтгэл ажилтай холбогдуулан арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэлд хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Үндэсний үйлдвэрүүдийн

Ирэх 2024 оноос эхлэн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж үндэсний үйлдвэрт тушааж, татварын цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдэж, баталгаажсан хонины ноосны килограмм тутамд 1000 төгрөг, тэмээний ноосонд 2000 төгрөг, сарлагийн хөөвөрт 10.000 төгрөгийн урамшуулал олгох, урамшууллыг 2028 оныг дуустал олгох тогтоолыг УИХ-ын чуулганаар баталсан.

эргэлтийн хөрөнгийн чадавх дээшилбэл түүхий эдийн худалдан авалт нэмэгдэж, үнэгүйдэл тодорхой хэмжээгээр багасна. Нөгөөтэйгүүр түүхий эдийн үнэ нь түүхий эдийн чанартай шууд холбоотой байдаг. Хэдийгээр малын тоо толгой өсөж, түүхий эдийн нөөц нэмэгдэж байгаа ч үйлдвэрүүд чанартай түүхий эдээр хангагдаж чадахгүй байна. Ялангуяа арьс ширний чанар нь малыг амьд байх үеэс эхлэн нядалж өвчих, чанарын хамгаалалт хийх, хадгалах, тээвэрлэх үе шат бүрд алдагдаж, үнэ цэнэ нь буурч байна. Иймд малчид малаа эрүүлжүүлэн гуур, шивээ гэх мэт арьс, ширний амьдын гэмтэл, нядалгааны үеийн арьс, ширний зүсэлтийн гэмтэл зэргийг багасгах, түүнчлэн чанарын хамгаалалтыг стандартын түвшинд хийх зэрэгт онцгойлон анхаарснаар түүхий эдийг үнийн уналтаас хамгаалах боломжтой юм.

- Махны экспорт, мал хөлөөр нь гаргах ажил хэр түвшинд явж байгаа вэ?

Манай улс амьд мал буюу эр хонь, эр ямаа экспортлох ажлыг 2022 оны 10 дугаар сараас зохион байгуулсан. Тухайлбал, 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 110 мянган хонь, ямааг амьдаар нь БНХАУ-д экспортлох ажлыг гүйцэтгээд байна. Замын-Үүдийн боомтоор жилд хамгийн ихдээ 150.0 мянган хонь, ямааг амьдаар нь гаргах боломжтой. Махны экспортын тухайд тухайн жил экспортлох болон импортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжид үндэслэн тогтоодог. Тус зөвлөлөөс гаргасан санал зөвлөмжийн дагуу 2024 оны 10 дугаар сар

хүртэл бүх төрлийн малын махны экспорт, импортын тоо хэмжээнд хязгаарлалт тогтоогоогүй. Өнөөгийн байдлаар энэ онд 70 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортлоод байна. Нийт экспортын 11%-ийг үхрийн мах, 36%-ийг адууны мах, 20%-ийг хонины мах, 33%-ийг ямааны мах эзэлж байна. Цаашид мал, махны экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулахын тулд малын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл бүс, хамгаалагдсан аж ахуй байгуулах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Малчдад төрөөс олгодог томоохон дэмжлэг бол арьс шир, ноосны урамшуулал. Гэвч өнгөрсөн 2022 оны урамшуулал одоог хүртэл олгогдоогүй байна. Ер нь цаашид олгох юм уу?

Ноосны урамшуулал тун удахгүй олгогдож эхэлнэ. Ирэх 2024 оноос эхлэн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж үндэсний үйлдвэрт тушааж, татварын цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдэж, баталгаажсан хонины ноосны килограмм тутамд 1000 төгрөг, тэмээний ноосонд 2000 төгрөг, сарлагийн хөөвөрт 10.000 төгрөгийн урамшуулал олгох, урамшууллыг 2028 оныг дуустал олгох тогтоолыг УИХ-ын чуулганаар баталсан. Тэгэхээр 2028 оныг дуустал олгоно.

- Цаашид ХХААХҮЯ-наас мал аж ахуйн салбарын талаар баримтлах бодлого, хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудынхаа талаар тоймлон мэдээлэл хүргээд ярилцлагаа өндөрлөх үү?

Бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын генетик нөөцийг хамгаалах, ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой сүлжээг бий болгох, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар анхаарч ажиллаж байна. Малын гаралтай түүхий эдийн үнэгүйдлийг арилгах, нэмүү өртөг шингэсэн арьс шир, ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Дархан арьс ширний цогцолбор”, “Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк” төслүүдийг хэрэгжүүлж буй. Мөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна даа.

Ярилцсан: С.Мөнхжаргал

ӨӨРТӨӨ БОЛОН ГЭР БҮЛДЭЭ АНХААРАЛ ТАВЬЖ, ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛААРАЙ...

Мал сүргээ онд мэнд оруулж, өвлийн хүйтнийг ажралгүй даван туулах арга замын талаар салбарын мэргэжилтнүүд, туршлагатай ахмад ажилтан, малчидтай хамт бэлтгэсэн зөвлөмжийг хүргэж байна.

- Хүн бүр өөрсдийн болон гэр бүлийнхнийхээ эрүүл мэндэд онцгой анхаарах;
- Цаг агаарын бэрхшээл, отор нүүдлийн үед дулаан хувцаслаж осгох, хөлдөхөөс сэргийлэх;
- Ахмад настан, жирэмсэн, нярай хүүхэдтэй эхийг аль болохоор гэр болон төв суурин газарт байлгах, отор нүүдлээр явуулахгүй байх;
- Эмнэлгийн яаралтай тусламж авах шаардлагатай тохиолдолд хамгийн ойрхон байгаа эмч эмнэлэгт хүрч болох зам, харилцах утасны лавлах, мэдээлэлтэй байх;
- Тэжээллэг хоол идэх, хүүхдийг хөхөөр дагнан хооллох, бага насны хүүхэд болон жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд тэжээлийн бэлдмэлийг тогтмол хэрэглүүлэх;
- Удаан хугацааны цасан шуургатай үед гэртээ орж гарч байх, хаалга үүд орчмын цасыг цэвэрлэж холтгож байхгүй бол гэрийн хаалга онгойхгүй болох аюултай;
- Хувийн ариун цэврийг сайтар сахих;
- Үхсэн малын сэг, зэмтэй болгоомжтой харьцан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж халдваргүйжилт хийх;



МАЛ СҮРГЭЭ ОНД МЭНД ОРУУЛАХ ЗӨВЛӨГӨӨ

- Өвөлжөө, бууц болон хэвтрийг дулаан хуурай байлгах
- Дулаан өвөлжөөнөөс аль болох нүүхгүй байх;
- Хашаа хороог хунгар цасанд даруулахгүйн тулд саравчны ард 15-20 метрийн зайтай 3-4 давхар хаалт хийх, саравчны дээд талд хоорондоо 5-7 метрийн зайтай



дарцаг 3-4-ийг босгох дарцагны хийсэлтийн нөлөөгөөр цас хол унадаг/;

- Хонь хотлох хашааны дотор баруун, зүүн хойд хэсэгт нүх ухаж хөлдсөн хоргол, нойтон шар бууц дүүргэн дарж овоолоод хонио хотлуулан хэд хоноход хөлдүү нь гэснэ. Энэ үед буцааж тараана. Бууцаар аль болох цөөн овоо хийвэл дулаанаа сайн барьж хатна. Бууц хатаах нүх нь 70-80 см гүн, өргөн, ургаараа нэг метр, хоорондоо 3-4 метрийн зайтай байна. Ийм нүхэнд хатаасан бууц 16-18 ам метр талбайд хүрэлцдэг;
- Цас ихтэй үед салхины зонхилох чиглэлийн дагуу хоорондоо 10 метр зайтай цасан хороог 2-3-ыг барьж хаалт болгох;
- Жавар ихтэй үед утаа, май тавьж, хашаа, пүнзний цан хүүргийг арилгах;
- Хот, хорооны үс, ноос, хогийг түүж цэвэрлэх.



Хүчтэй, хүйтэн цасан шуурганы үеэр хотонд байгаа малын нүд цантдаг. Малын нүд цантах нь мал уруудах нэг шалтгаан болдог. Малын нүд цантсан эсэхийг харж анзаарч байх, цанг арилгах...

- Малыг халуун хэвтрээс нь хөөж тууж гаргах бус харин хөдөлгөж хашаанд нь түр байлгасны дараа таваар гаргах;
- Хүчтэй, хүйтэн цасан шуурганы үеэр хотонд байгаа малын нүд цантдаг. Малын нүд цантах нь мал уруудах нэг шалтгаан болдог. Малын нүд цантсан эсэхийг харж анзаарч байх, цанг арилгах;
- Гэрүүдээ чандманалан барих буюу тэрэгний арлуудыг босгож хашаа дамжуулан тавьж берзинг, нөмрөгөөр саравч хийх, малаа уруудахаас хамгаалах;
- Дальпууг ашиглан бэлчээрийн зам гаргахаас гадна өвс сайтай бэлчээрийг хамгийн түрүүн гаргаж ашиглах;
- Цас ихтэй газрын бэлчээрийг адуу бэлчээж, хөрлөсөн цасыг задлах;
- Малаа нөмөр газар бараадуулан хариулах;
- Муудсан малыг бүлээн усаар усалж байвал тэнхрэх нь хурдан байдаг бөгөөд сувилж, тэжээж байгаа малыг услахдаа нэг литр бүлээн усанд амны халбага давс уусгаж услах;
- Малд хүчит тэжээл өгөхөөс өмнө заавал усалсан байх, тэжээлийг урьдчилж дэвтээх шаардлагатай.
- Хэт их доройтсон, өргүүлж байгаа малд сувиллын чанартай тэжээл бэлтгэн ойр ойрхон тордож тэжээх, мөн адууны элэг, өөх, малын хатаасан цус, шимт ургамлын зоодой, цайны шаарыг ханд, зутанд холих зэргээр өглөө, оройд бага багаар өгөх;
- Огосон малыг хүйтэн ус өгч биеийг нь үрж дулаацуулан хучих, адууны махны шөл, шар тос, сонгино, сармис өгнө. Харин огосон малыг гэнэт дулаан байр, гэрт оруулж болохгүй бөгөөд халуун, бүлээн цай өгч болохгүй.

М.ГАНБААТАР:

ЦӨӨН ТООНЫ ЧАНАРТАЙ МАЛТАЙ БАЙХ НЬ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХАД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ

Энэ удаагийнхаа дугаарын зочноор Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд, “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь”/АДАПТ/ төслийн удирдах хорооны дарга М.Ганбаатарыг урьж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, зудын эрсдэл, бэлчээрийн асуудлаар ярилцлаа.



- Урилгыг маань хүлээж авсан танд баярлалаа, хоёулаа бэлчээр, уур амьсгал, цөлжилтийн эсрэг танай яамнаас хийгдэж буй онцлох ажлуудаар ярилцлагаа эхлэх ҮҮ...

За тэгье. Намайг дугаарынхаа зочноороо урьсан танай сэтгүүлийн хамт олонд баярлалаа. Цөлжилт, газрын доройтлын асуудалд салбар дундын уялдаа маш чухал. Учир нь Засгийн газрын тухай хууль, яамдын чиг үүргийн дагуу газрын асуудал БХБЯ-нд, бэлчээрийн асуудал ХХААХҮЯ-ны эрхлэх асуудал байдаг. Манай БОАЖЯ цөлжилт, газрын доройтлыг бууруулах, хамгаалах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй. Энэ хүрээнд газрын доройтол, бэлчээр, тариалангийн

талбайн хөрсний чанарын судалгааг тогтмолжуулж, доройтсон газрыг нөхөн сэргээж ургамалжуулах, ойжуулах, агро ойг хөгжүүлэх, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан эдийн засгийн эргэлтэд оруулах, ухаалаг хөдөө аж ахуйн шийдлүүдийг нэвтрүүлэх зэрэг салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа зохицуулалтыг хангасан бодлогыг нэн тэргүүнд хэрэгжүүлж байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтолтой тэмцэх шинэ арга зам, боломжуудыг эрэлхийлж, амжилттай хэрэгжсэн сайн туршлагуудыг хуваалцаж, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх боломжтой, үр дүнтэй гарц, шийдлийг бий болгоход гол анхаарлаа хандуулж буй. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хувьд

төр, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, мэдээллээр хангах, иргэд, олон нийтэд уур, амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагавар, түүнийг сааруулах, нөхөн сэргээх, хүнсний аюулгүй байдлыг хангах арга зүйн талаар мэдлэг олгох сургалт, компани ажил өрнүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

- Уур амьсгалын өөрчлөлт дэлхий даяар хүчтэй явагдаж, үр нөлөө нь багагүй эрсдэл, хохирол авчирч байна. Манай улсын хувьд байгаль цаг уурын өөрчлөлтийн нөлөөнд хамгийн их өртдөг хүмүүс бол малчид л даа...

Тийм ээ. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн Монгол Улсад



сүүлийн 70 жилийн хугацаанд агаарын дундаж температур цельсийн 2.1 градусаар нэмэгдсэн төдийгүй газар нутгийн 80 орчим хувьд доройтол үүссэн судалгаа гарсан. Мөн зуд, ган, цасан болон шороон шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж хурдтайгаар нэмэгдэж байгаа нь хүн амын 30 шахам хувийг эзэлдэг Монгол орны малчдын уламжлалт амь амьжиргаанд хүндээр тусч байна. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тэдний эрсдэлийн менежментийн чадавхад дэмжлэг үзүүлэх нь Монгол Улсын хувьд онц ач холбогдолтой болоод байгаа. Жилийн дөрвөн улиралд байгалийн нөхцөлөөс шууд хамааралтай байдаг малчдын хувьд мал маллагааны арга ажиллагаа дутмаг, малынхаа тоо толгойг зохисгүй хэмжээнд өсгөж ирсэн нь улам бүр эмзэгшиж буй экосистемийн үйлчилгээнд давхар нэрмээс болж байна. Тийм учраас мал аж ахуйгаа цаг уурын нөхцөл байдалтайгаа уялдуулж төлөвлөж, авч явах зайлшгүй шаардлагатай. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс жил бүр өвөл, хаврын

Монгол орон
80 сая
хонин толгой
бэлчээрийн
даацтай, гэтэл
энэ тоо өнөөдөр
нийт **110 саяд**
хүрээд байгаа нь
бэлчээрийн даац
хэтэрснийг шууд
харуулж байна.



бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн тооцоолон гаргадаг. Тус

судалгаагаар 2022-2023 онд өвөл, хаврын бэлчээрийн даац нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 60 гаруй хувьд хэтэрч гарсан. Бэлчээрийн зохицуулалтгүй хэт ашиглалт, талхагдал нь байгалийн ургамалд нөхөн төлжих хугацаа, боломж олгохгүй хомсдох, улмаар устахад хүргэж байна. Манай улсын газар нутгийн 70.7 хувийг бэлчээрийн талбай эзэлж, 69 хувь нь доройтолд орсон тухай судалгаа гарсан. Бэлчээрийн талбайн хэмжээ сүүлийн 50 гаруй жилд 20 орчим хувиар буурч, эсрэгээрээ малын тоо толгой сүүлийн 30 жилд 3 дахин өссөн. Монгол орон 80 сая хонин толгой бэлчээрийн даацтай, гэтэл энэ тоо өнөөдөр нийт 110 саяд хүрээд байгаа нь бэлчээрийн даац хэтэрснийг шууд харуулж байна. Үүнд мал сүргийн 40 хувийг ямаа эзэлж байгаа нь бэлчээрийн доройтолт үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байна. Тиймээс манай малчид цөөн тооны чанартай малтай байх нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чухал нөлөөтэй.

- Малчид уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чухал нөлөөтэй гэснээс бэлчээрээс

болж малчид нэгнийхээ аминд хүрсэн харамсалтай хэрэг хэд, хэд гарлаа. Энэ талаар таны байр суурийг сонсьё...

Ер нь бол бэлчээрийн хувьд хууль эрхзүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Тэр хуулийнхаа хүрээнд л бэлчээрийн асуудал зохицуулагддаг байх учиртай. Яах вэ, малчин түмэн бол олон зууны туршид нүүдэллэн аж төрж, газар нутгаа хайрлан, сахин хамгаалж, энэ Монголын өргөн уудам тал нутгийг эзэнтэй байлгаж буй улс. Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг гэж ардын сайхан үг бий. Хоорондоо сайхан зохицох л асуудал шүү дээ. Монгол хүмүүс байна даа. Бэлчээрийн одоогийн төлөв байдлыг үнэлэн даацыг шинэчлэн тогтоож, түүндээ тохируулан малын тоо толгойг зохистой хэмжээнд барих, эрүүлжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эдийн засгийн аргаар ашиглалтыг зохицуулан бэлчээрийг сэргээж, хэвийн байдлыг хадгалж, бэлчээрийн мал аж ахуйд нүүрлэж байгаа эрсдэлийг бууруулах шаардлага байгаа. Үүнийг төр бодлогоор зохицуулах учиртай.

- Сүүлийн жилүүдэд говийн болон баруун аймгуудын нутгуудаар хэдэн жил дамнасан ган, зуд тохиолдож, цөлжилт хүчтэй явагдаж байна. Үүний эсрэг, урьдчилан сэргийлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Цөлжилтийг сааруулахтай холбоотой жил бүр баглагдсан төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөр, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийт 200 гаруй га талбайд цөлжилтийг сааруулах, хамгааллын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. 2020 онд цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр элсний нүүлтийг сааруулах, говийн баянбүрдийг нөхөн сэргээх арга хэмжээг нийт 70 га талбайд, 2021 онд цөлжилт, газрын доройтолд хүчтэй өртсөн аймгуудад 110 га талбайд хамгаалалтын зурвас байгуулж, 2022 онд Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий аймагт 79 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулсан.

Уур амьсгалын ногоон сангаас санхүүжүүлэн, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр **“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” /АДАПТ / төслийг манай Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран долоон жилийн хугацаатай хэрэгжүүлж байгаа.**



2023 онд Газрын доройтол бууруулах цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээнд Говьсүмбэр аймагт 85,0 сая төгрөгөөр 10 га талбайд байгалийн ургамал тарих, Булган аймагт 72,0 сая төгрөгөөр 8 га талбайд механик хаалт байгуулах, Дундговь, Говь-Алтай, Говьсүмбэр, Өвөрхангай аймагт тус бүр 8 га талбайд 90 сая төгрөгөөр хамгаалалтын ойн зурвас байгуулахаар зардлыг шийдвэрлэж орон нутагт эрхийг шилжүүлээд байна. Цөлжилт, бэлчээрийн доройтол, малчдыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр НҮБ-ээс хэд, хэдэн төслүүд манайд хэрэгжиж, малчид маань үр дүнг нь хүртэж буйд бас баяртай байгаа.

- Онцлон хэлбэл ямар төсөл байна вэ?

Монгол Улсын хүн амын гуравны нэг хувийг малчин өрх эзэлдэг төдийгүй хөдөө аж ахуйн салбарын 90 хувийг бүрдүүлдэг. Улсын хэмжээнд нийт аймаг, сумдын эдийн засгийн 85 орчим хувь нь хөдөө аж ахуйд суурилдаг. Таны дээр хэлсэнээр манай малчин өрхүүд уур амьсгалын эрсдэл, нөлөөлөлд хамгийн их өртөж, нэрвэгддэг учраас түүнд тохирсон хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хөдөө аж ахуйн салбар, эдийн засаг болон байгаль орчинд үр шимээ өгөх, уур амьсгалын хүчин зүйлийг илүү харгалзсан, мал маллагааны зохистой арга технологид шилжихэд дэмжлэг болох юм. Энэ зорилтын үүднээс Уур амьсгалын ногоон сангаас санхүүжүүлэн, НҮБ-ын Хөгжлийн

хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь”/АДАПТ / төслийг манай Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран долоон жилийн хугацаатай хэрэгжүүлж байгаа. Миний бие төслийн удирдах хорооны даргаар нь ажилладаг. Төсөл уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар гэсэн дөрвөн аймгийн байгалийн нөөцөөс хамааралтай хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамжийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжиж байна.

- Төслийн үр дүн хэр гарч байна вэ?

Эхнээсээ сайхан үр дүн үзүүлж байна. Тухайлбал Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймгийн 68 сумын 14 сав газар, 36.44 сая га талбайд экосистемийн даац, үйлчилгээ сайжруулах тал дээр тодорхой үр дүн гарсан. Төслийн гол зорилго нь малчдын амьжиргаа, амьжиргааны эх үүсвэр болсон байгалийн нөөцөд үзүүлж буй уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад цогц байдлаар хандах юм. Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран зудын эрсдэлийн талаар томоохон судалгааг хийсэн. Үүнийгээ үндэслэж бид өвөлжилт, хаваржилтын төлөвлөгөөгөө гаргаж, бэлтгэлээ базааж байна. Малын



гүн өрмийн худаг барьж байгуулах, хуучин худгийг засаж сэлбэх ажлуудыг цөөнгүй хийж байгаагаас гадна сайн чанарын малтай суурь, өрх, малчдын бүлэг дээр мэргэжлийн малзүйчдийн тусламжтайгаар цөм сүргийг бий болгоод байгаа. Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжсэн төр, хувийн хэвшил, нөхөрлөлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж, түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэлийн бүх үе шатанд өртөг нэмэгдүүлэх, газар дээр нь хадгалах зэрэг агуулгыг багтаасан сургалтуудыг зохион байгуулж байна. Өвс, тэжээлийн агуулах саравчуудыг бас нэлээд их барьсан. Мал аж ахуйн үйлдвэрлэл, үржил, удам зүйн ажилд томоохон ахицуудыг үзүүлж буй. Энэ мэтээр төслийн хүрээнд дорвитой ажлууд хийгдэж, үр дүн ч гарч эхэлж байгаа.

- Цаг зав гарган ярилцсан танд баярлалаа. Цаашид хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлуудынхаа талаар тоймлон мэдээлэл хүргээд ярилцлагаа

өндөрлөх үү?

За тэгье. Монгол орон уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй улсын тоонд багтаж, хур тунадасны хэмжээ буурснаар цөлжилт, хуурайшилт нэмэгдэж, бэлчээр, усны нөөц багасаж, байгалийн бүс бүслүүр шилжихэд хүрээд байна. Түүнээс гадна зуд турхан ган гачиг, их цас унах, шар усны үер буух болон хэт халж, хэт хүйтрэх зэргээс учрах гамшигт үзэгдлийн давтамж, эрчимтэй нэмэгдэх боллоо. Тиймээс бид уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг дасан зохицох чадварт сургах, соргог бэлчээрийг хамгаалж, байгалийн бүс бүслүүрийн онцлогт тохируулан үрийн нөөцийг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтөд өртсөн газар нутгийг байгалийн ургамлын үрээр нөхөн сэргээх, ургамалжуулах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Түүнчлэн хөрсний үржил шим, чийгийг хамгаалах, механик эвдрэлээс сэргийлэх, байгалийн хөрсийг хөндөхгүй байх, нутгийн унаган ургамал, хуурай, халуун нөхцөлд тэсвэртэй тэжээлийн

ургамал тариалах, цөлжилт, газрын доройтлыг бууруулах арга хэмжээнд шаардлагатай бодит төсвийн тооцоог гаргаж санхүүжилтийг нэмэгдүүлнэ. Цөлжилтийг бууруулах, доройтсон газрыг сэргээх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, санаачилгыг дэмжих урамшууллын механизм, эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх, шаардлагатай байгаа. Үүнийг шийдүүлэхийн төлөө ажиллана. Түүнээс гадна Монгол орны нөхцөлд тохирсон цөлжилттэй тэмцэх, элсний нүүдлийг барих технологи туршин нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Мэдээж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож ажиллаж, амьдрах, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр малчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд байгальд ээлтэй дэвшилтэт, ухаалаг технологи хэрэглэх талаарх малчдын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна даа.

Ярилцсан: С.Мөнхжаргал



"МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ"(АДАПТ) ТӨСӨЛ



"АДАПТ" ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ 800,000 МАЛЧИН ӨРХ ХҮРТЭНЭ

Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь"(АДАПТ) төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Байгалийн нөөцөөс хамааралтай уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх зорилгоор 2021-2028 он хүртэл долоон жилийн хугацаанд Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгуудын 68 суманд хэрэгжүүлэх уг төслийн үр шимийг шууд болон шууд бусаар 800,000 малчин хүртэх бөгөөд үүнээс 50 хувь нь эмэгтэй малчин юм.



Зорилтот дөрвөн аймаг, 68 сумын Засаг даргын тамгын газар, бусад холбогдох төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд, байгалийн нөөцийн хамтын менежментийн

байгууллагууд, малчдыг оролцуулан хэрэгжүүлж буй "АДАПТ" төслийн үр дүнд байгаль цаг уурын өөрчлөлтөд малчдын дасан зохицох чадамж сайжирч, бэхэжнэ гэсэн хүлээлттэй

байгаа юм. Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд, "Алсын хараа-2050" болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, "Үндэсний тодорхойлсон хувь

ТӨСЛӨӨС ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН:

ХАМРАХ ХҮРЭЭ: Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймгийн **68 сум**

- **ШУУД ҮР ШИМ ХҮРТЭГЧИД: 130,000 хүн**
- **ШУУД БУСААР ҮР ШИМ ХҮРТЭГЧИД: 800,000 хүн**
 - Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг иргэд, орон нутаг, бүс нутгийн өртөмтгий байдал багасаж, даван туулах чадвар нэмэгдсэн байна.
 - Аймаг, сумын хөгжлийн төлөвлөлтийг бэлчээрийн даац, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд үндэслэн гаргах, гол мөрний сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
 - Экосистемийн даац, үйлчилгээ сайжирсан байна. 14 САВ ГАЗАР, 36.44 САЯ ГА
 - Малчид уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал сүрэгтэй болох, гарал үүсэл нь тогтвортой чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд харьцангуй өндөр үнэтэй нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
 - Уур амьсгалын мэдээлэлд түшиглэсэн төлөвлөлтийг дэмжсэн институтын болон зохицуулалтын тогтолцоо бэхэжсэн байна.
 - Уур амьсгалын мэдээлэл боловсруулж, ашиглан шийдвэр гаргах байдал сайжирсан байна.
 - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж сайжирч, өртөх эрсдэл буурсан байна.

БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

1. Үндэсний болон орон нутгийн түвшинд газар, усны ашиглалтыг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, хэрэгжүүлдэг болох
2. Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэн, байгалийн нөөцийн менежментэд малчдын оролцоог нэмэгдүүлэх
3. Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малчдын байгууллагын чадавхыг нэмэгдүүлж, бэхжүүлэх

нэмэр"-ийн баримт бичигт тусгагдсан тэргүүлэх чиглэлүүдтэй уялдан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний нөлөөллийг сааруулахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилготой "АДАПТ" төсөл нь гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжиж байна.

"АДАПТ" төсөл хэрэгжсэний үр дүнд төслийн хүрээний аймаг, сумдын олон зуун малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж сайжирч байгаагийн зэрэгцээ ган, зудын эрсдэлийг урьдчилан төлөвлөн бэлтгэл ажлаа сайтар хангаж, байгалийн хүндрэлийг харьцангуй хохирол багатай даван туулж байна. Төслийн хүрээнд олон үр дүнтэй ажлууд хийгдэж буйгаас зөвхөн мал аж ахуйн үйлдвэрлэлд гэхэд олон арван худаг шинээр баригдаж, бэлчээрийн усан хангамж сайжирч, хэдэн мянган хүн, мал ундаалж байгаагаас гадна хатаж, ширгэх аюулд өртсөн цөөнгүй булаг, шанд хамгаалагдаад байгаа юм.

Мөн урсац бүрдэх эх болон гол мөрний эх сав газрын унаган төрх, экосистемийг хамгаалах, усны



хэмнэлттэй технологи нэвтрүүлэх замаар усны нөөцийн хүрэлцээг хангах зорилгоор уур амьсгалын өөрчлөлтөд ихээр өртсөн голын эх бүхий талбайд татмын ойжуулалтын ажлыг хэрэгжүүлж усны нөөц, экосистемийн үйлчилгээг тэтгэжээ. Түүнчлэн зах зээлд борлуулахаар ирүүлж буй малд эрүүл мэндийн үзлэг, ангилалт, ялгалт хийх, мал борлуулах зэрэг ажилд шаардлагатай мал ачих, буулгах тавцан бүхий малын зөөврийн хашааг хийж өгснөөс гадна цөөнгүй өвс,

тэжээлийн агуулах саравчийг барьж, малчдыг байгалийн эрсдэлтэй үеийг хохирол багатай даван туулах боломжоор хангаад байгаа юм. Төслийн зорилтод дөрвөн аймгийн малчдад цөм сүргийн суурийг болгож өгснөөр баг, сум цаашлаад аймгийн хэмжээнд мал сүргийн чанар сайжрах томоохон ажлын эхлэл тавигдаад буй. Ийн "АДАПТ" төсөл хэрэгжсэний бодит үр дүнгүүд гарч, үр шимийг нь олон зуун малчид хүртэж байна.





Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум, Баянзүрх булаг, 2023 он


2023 онд орон нутгийн хамтын санхүүжилттэйгээр нийт 24 булгийн эхийг хамгаалж, 32 худаг гарган усны хүртээмжийг нэмэгдүүлснээс гадна, 710 га талбайд татмын ойжуулалт, нөхөн сэргээлт хийх болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өвс, тэжээлийн 9 агуулах барих, 11

агуулах засварласан зэрэг дасан ажлуудыг 103 байршилд хэрэгжүүлжээ. Ийн ажилласны үр дүнд зорилтот 4 аймгийн 49 сумын 15.000 гаруй малчин өрх үр шимийг нь хүртээд байна.



ТӨСӨЛ НЬ ЗОРИЛТОТ 4 АЙМАГТ 2027 ОН ХҮРТЭЛ


88 БУЛГИЙН ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛХААС




48 ӨВС ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХ БАРИХААС



2500 ГА-Д ТАТМЫН ОЙЖУЧЛАЛТЫГ ХИЙХЭЭС



285 ХУДАГ УС, ЦООНОГ ГАРГАХААС



МАЛЫН ЧАНАР, ҮҮЛДЭР УГСААГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

ЗАВХАН АЙМАГТ



САРТУУЛ ХҮЦ
4 ТОЛГОЙ



ЗАВХАН БУУРАЛ УХНА
4 ТОЛГОЙ



ЭМ ЯМАА
20 ТОЛГОЙ



ЭМ ХОНЬ
20 ТОЛГОЙ

ДОРНОД АЙМАГТ



ДОРНОД МОНГОЛЫН УЛААН БУХ
4 ТОЛГОЙ



БУРИАД ХҮЦ
4 ТОЛГОЙ



ЭМ ХОНЬ
20 ТОЛГОЙ

СҮХБААТАР АЙМАГТ



ҮЗЭМНИН ХҮЦ
4 ТОЛГОЙ



БАЯНДЭЛГЭР УЛААН УХНА
4 ТОЛГОЙ



ЭМ ЯМАА
20 ТОЛГОЙ



ЭМ ХОНЬ
20 ТОЛГОЙ

ХОВД АЙМАГТ



СҮГТЭЙ ХҮЦ
4 ТОЛГОЙ



АЛТАЙН УЛААН УХНА
4 ТОЛГОЙ



ЭМ ЯМАА
20 ТОЛГОЙ



ЭМ ХОНЬ
20 ТОЛГОЙ

НҮҮХ ҮҮ, ҮЛДЭХ ҮҮ?

Жил ирэх бүр ган, зудын давтамж нэмэгдэж хатуухан хэлэхэд бэлчээрийн мал маллах боломжгүй боллоо. Өнөөдөр малчид хүний нутагт хөөгдөн туугдан отор нүүдэл хийж үлдэж амьдрах уу, эсвэл малаа зараад суурин газар руу ажил хийхээр нүүх үү гэсэн хоёр сонголтын дунд "тийчилж" байна. Угтаа бол нүүдлийн мал аж ахуй нь бидний дэлхийд ондооших онцлог, хэдэн мянганыг өртөөлсөн ахуй соёл, өв хөрөнгө юм. Малчид бол Монголын хөдөөгийн буурал түүхийг нөр хөдөлмөр, зүтгэлээрээ бүтээж, улсынхаа эдийн засагт үлэмж хэмжээний хувь нэмрээ оруулж, бэлчээр газар нутагтаа эзэн нь байж хайрлаж хамгаалан, нүүдэлчин өв соёлоо өвлүүлэн тээж, дөрвөн цагийн эргэлтэд мал сүргээ өсгөн үржүүлж эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмрээ оруулж яваа баялаг бүтээгч. Тэр ч угтаараа Монгол Улсын Үндсэн хуульд "Мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна" гэж заасан байдаг. Гэтэл өнөөдөр энэхүү баялаг устгах аюулд тулхчаад байна. Тиймээс төр засгаас орчин үетэйгээ нийцсэн оновчтой, алсыг харсан, хөрсөн дээрээ буусан зөв бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нэн шаардлагатайгаас гадна малчид ч цаг үеийн нөхцөл байдалтайгаа уялдуулж аж ахуйгаа төлөвлөж авч явах зайлшгүй цаг үе ирсэн. Яг үнэндээ өнөөдөр гадны төслүүд л энэ салбарын тулгамдсан асуудлуудыг шийдэж буй. Тухайлбал "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь"/АДАПТ/ төсөл байна. Төслийг уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хөдөөгийн малчдад тулгарч буй дээрх бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Завхан, Ховд, Дорнод, Сүхбаатар аймгийн 68 суманд хэрэгжүүлж байгаа билээ. Тус төслийн үр шимийг хүртэж буй бодит жишээг хүргэе.

ХОВД АЙМАГ



Ховд аймгийн Мөст сумын Хужирт баг байгалийн эрс тэс уур амьсгалтай өндөрлөг газар оршдог учир эрт үеэсээ л малынхаа тоо толгойг зохистой түвшинд барьж ирсэн байдаг. Тэр л зарчмаар тус багийн залуу малчин Ч.Лхайсүрэн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны хуваарийг чанд баримтлан, бэлчээрт ээлтэй үхэр, хонь түлхүү өсгөж, ямааныхаа тоо толгойг бууруулж иржээ. Түүнчлэн жил бүр 100-250 малыг эдийн засгийн эргэлтэд тогтмол оруулж, орон нутгийнхаа хүнсний хэрэгцээнд хувь нэмрээ оруулдаг байна. Сүүлийн зудтай жилүүдэд тэрбээр өнчин ишигний гарзгүй малаа онд мэнд бүрэн оруулсан туршлагатай, ажилч, хөдөлмөрч залуу. Сүргийн эргэлтийн төлөвлөгөөг бог малд гурван жил тутамд, бод малд хоёр жил тутамд эцэг малыг сольж, үржлийн ажлыг

зохион байгуулж, малаа чанаржуулж ирсэн юм. Дөрвөн төрлийн 691 толгой малтай Ч.Лхайсүрэнгийн гэр бүл 2018 онд "Баян төл" хоршооны гишүүнээр элсжээ. Хоршооны удирдлагаас "Тогтвортой ноос ноолуурын эвсэл"-ээс хэрэгжүүлж буй "Бэлчээрийн зохистой ашиглалт ба мал аж ахуйгаа хөтлөх, ноолуур бэлтгэх" хоёр зохистой дадлын заалт бүхий стандартыг даган бэлчээр, зэрлэг ан амьтадыг хамгаалах, нөхөн сэргээх, мал аж ахуйгаа өнөө үедээ төдийгүй үр хойчдоо өвлүүлэн үлдээхэд шаардлагатай арга ажиллагааг хөдөөгийн ахуй амьдрал, өв соёлдоо нийцүүлэн ажиллаж байна. Эхнэр А.Уянга нь малынхаа ашиг шимийг бүрэн авахаас гадна, сүү, цагаан идээгээ боловсруулан өрхийн хэрэгцээнээс илүү гарсныг нь зах зээлд борлуулдаг. Залуу гэр бүл жил

бүр хоршоондоо мах, ноос, ноолуур, арьс, шир, хөөвөр, адууны дэл, сүүлийг стандартын дагуу бэлтгэн нийлүүлдэг аж.

Залуу малчин Ч.Лхайсүрэн "Аав, ээжийнхээ малч удмыг залгамжлан малаа маллаж явна. Малынхаа тооноос илүү чанарт анхаардаг. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэлээ эртнээс сайтар бэлтгэж, хангалттай хэмжээнд өвс, тэжээл нөөцөлдөг. Өөрийнхөө малд өгдөг хужир, шүүгээ зэргэлдээ янгир идээшилдэг газар тавьж зэрлэг амьтадтай хуваалцаж буян болдог юм. Мал бол бидний эцэг өвгөдөөс уламжлагдаж ирсэн өв хөрөнгө, буян, бидний болон үр хүүхдэд маань өвлөгдөх хөрөнгө, ирээдүйнх нь баталгаа юм. Тиймээс ганц төлгийг ч үхүүлэхгүй, онд оруулахын төлөө хөдөлмөрлөж зүтгэж явна даа." хэмээн хүүрнэн лээ.



Ховд аймгийн төлөөлөл

СҮХБААТАР АЙМАГ

НУТГИЙН ОЛНЫ “ДАЛАЙ” БОЛСОН ХӨӨВРИЙН БУЛАГ

Манай орны говь, хээрийн бүс нутагт байх нуур тойром, булаг шанд нь экологийн хувьд чухал ач холбогдолтой төдийгүй хүн, малын ундны усыг хангагч, зэрлэг амьтад, нүүдлийн шувуудын амрах газар болдог гадаргын усны гол эх үүсвэр буюу “чандмань эрдэнэ” юм. Төслийн зорилтот аймгуудын нэг Сүхбаатар аймгийн зарим сумд нь Галба-Өөш, Долоодын ай сав газарт хамаарах бөгөөд гадаргын ус ховор, гүний усаар хэрэглээгээ хангадаг говь, хээрийн бүс нутаг юм. Энэхүү сав газрын жилийн дундаж агаарын температур 1961-2021 оны хооронд 2.4°C-аар нэмэгдсэн бөгөөд ялангуяа өвөл, хаврын улиралд илүү эрчимтэй (3-3.1°C-аар) дулааралт ажиглагдах болсон. Хүйтний улирлын хур тунадас 12.2 хувиар нэмэгдэж, дулааны



улирлын тунадас бараг өөрчлөлтгүй байгаа нь чийгийн хангамж дутмаг тус нутаг дэвсгэр дэх хуурайшлыг улам бүр эрчимжүүлж байна.

Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилттэйгээр МУ-ын Засгийн газар, НҮБХХ хамтран хэрэгжүүлж буй “АДАПТ” төслөөс хүн, малын ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэхэд гадаргын

усыг ашиглах, тогтмол байлгахад анхаарч нийт зорилтот 4 аймгийн хэмжээнд хоёр жилийн хугацаанд 32 булгийн эхийг хашиж хамгаалаад байна. Түүний нэг нь Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт байрлах Хөөврийн булаг юм. Нутгийн иргэдийн амьдралын гол эх нь болсон булгийн урсац малын хөлд дарагдан, усны ундарга нь татарч бохирдон, ширгэсэн тул төслийн хүрээнд 2022 онд булгийн эхийг хашиж хамгаалснаар нэгхэн жилийн дотор гайхалтай үр дүн гарсан билээ. Одоо Хөөврийн булаг нь далай мэт урсаж булгийг тойрон нутаглах 25 өрх малчдын сэтгэлийг тэнийлгэн, 30 гаруй мянган мал, амьтдын ундаалан цугладаг сайхан газар болжээ.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын малчин У.Гантоого, гэргий П.Саруултай Хөөврийн булгийн талаар товчхон ярилцсаныг хүргэе.



- Та өөрийгөө болон Хөөврийн булгийнхаа талаар товчхон яриа өрнүүлэхгүй юу...

За тэгье. Намайг У.Гантоого гэдэг. Сүхбаатар аймгийн Дарьганга суманд төрж, өссөн. Найман жилээ төгсөөд цэргийн алба хааж ирснийхээ дараа 2007 онд ханьтайгаа гэр бүл болж, Хөөврийн булгийнхаа ойролцоо нүүдэллэн амьдарч байна даа. Манайх анх 100 хүрэхгүй малтай байсан бол одоо 15 жилийн дотор хонь, ямаа нийлсэн 700 гаруй бог, 40-өөд үхэр, 30 гаруй адуутай. Намайг анх мал маллаж эхэлж байхад бэлчээрийн даац боломжийн байсан. Одоо ч айлууд ойр, ойрхон бууж, мал их өсөж байгаа учраас бэлчээрийн даац муудаж, ус ховордох боллоо. Өвөлжөөнөөсөө буугаад

хавар ирэхэд манай булгийн ус хонхроо дүүргэсэн байдаг. Гэтэл мал их шаваад ирэхээр ус нь амархан ширгээд, баруун, зүүн хэсгээрээ тасарчихдаг болсон. Сүүлдээ адуу, мал орж зогсоод даац нь хэтэрдэг юм уу, багасаад байхгүй болчихдог байсан.

Гэргий П.Саруул: “Манай хөөврийн булаг бид хоёрыг анх тусдаа гарч байхад их сайхан урсацтай байлаа. Гэтэл сүүлийн гурав, дөрвөн жилээс ус нь ширгээд эхэлсэн. Хөөврийн булгийг тойроод одоо 20, 30-аад айл бууж, мал ихэссэн. Харин 2022 онд булгийн эхийг хашиж хамгаалснаас хойш усны урсац сайн болсонд баяртай байгаа. Хашихаас өмнө шөнө 12 цаг гээд малчид урладаад л

малаа усалдаг, усалж амжаагүй нь буцаад малаа туугаад явдаг байлаа. Өдөр нь уух усгүй, мал шаваад л, мөн дэл сул малууд зөндөө орно. Ус нь бутгиород дан шавар болчихдог байсан. Ус муутай болохоор булгаа орхиод задгай ус бараадаад нүүцгээнэ. Зун 4-5 удаа нүүх үе ч зөндөө л байлаа. Бороо орж, нуур тогтсон газар нүүгээд очихоор хэдхэн хоноод л тогтоол ус учраас алга болчихно. Тэгээд гол, устай сайхан газар очихоор мал идэх ногоогүй учир мал тогтохгүй дахиад л нүүнэ. Хашсанаас хойш оочир, дараалал байхгүй, мал маань зөнгөөрөө усруугаа орчихно. Ёстой сайхан, бидний амьдрал амар тайван, мал тарган тавтай байна. Энэ жил бас зуншлага сайтай, хур бороо ч элбэг жил байлаа. Анх хаваржаанаасаа нүүгээд ирэхэд хөөврийн булаг чинь яг ийм гоё энэ жилийнх шиг байдаг байсан. “Энэ жил манай хөөврийн булаг далай шиг байна даа...” гэж манай нутгийнхан ярьж байна.”



2023 он Хөөврийн булаг

ЗАВХАН АЙМАГ

Малчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх нь...



Бэлчээрийн хомсдол, ган, зудын нөлөөгөөр жил бүр Завхан аймгийн Цэцэн-Уул сумын 50 орчим өрх айл, 60-70 мянган малтайгаа отрын бүс нутагт өвөлжөөд хавар нутагтаа эргэж ирдэг. Малчид тус аймгийн Ургамал сумын хойд талаар зүүн тийш Хүнгийн голыг хөвөөлөн үргэлжилдэг элсэн манхны сүвээр 25км орчим тэмээн хөсгөөр нүүдэллэдэг. Эдгээр айл өрхийн төлөөлөл бол тус сумын Сангийн далай багийн малчин Ж.Цогзол юм. Тэрээр бага наснаасаа энэ нутагт амьдарч байгаа бөгөөд 20 гаруй жил мал маллажээ.



Ж.Цогзол “Сүүлийн жилүүдэд цаг агаар ихээхэн өөрчлөгдөж байна. Өвөл нь маш хүйтэн болж, хавар нь өвлөөсөө ялгаагүй хүйтэрч, шуурдаг болжээ. Энэ жилийн хувьд манай нутагт

өвөл маш хүнд болсон. Тэжээл муутай байсан тул отроор явахаас өөр аргагүй байлаа. Малчдын хувьд элсэн манхныг давж, отор нүүдэл хийх нь маш хүнд байдаг. Элсэн цөлөөр машин техник явах ямар ч боломжгүй. Тиймээс тэмээ, мориор малаа туун ямар ч өвс тэжээл, усгүй элсэн манхныг давахаас өөр арга байдаггүй. Мал тэнхээтэй бол өглөө маш эрт гарахад оройхондоо давчихдаг. Харин тарга тэвээрэг муутай бол хэд хонох ч тохиолдолд байдаг. Элсэн манхныг туулахгүй бол тойруу замаар сар орчим явж отрын нутагт очдог” хэмээн уур амьсгал хэрхэн өөрчлөгдөж байгаа болон малчид хэрхэн даван туулдаг талаар ярилаа. Мөн тэрбээр өвлийн хүнд цагт ам бүл цөөтэй болон өрх толгойлсон эмэгтэй малчдад отор нүүдэл хийх хэцүү байдгийг хуваалцсан юм. Ж.Цогзол цааш нь “Малчин хүний амьдралд хэцүү бэрх

зүйл байдаг. Малчин хүн өөрийгөө зөнд нь хаяад малынхаа төлөө л явдаг. 2018 оны өвөл нөхөртэйгөө хамт малаа туугаад элсэн манхныг давж байлаа. Хоёулхнаа учраас малаа хувааж туух, шөнийн хүйтэнд ээлжээр гарч гал түлж утаа тавих зэргээр хэдэн малаа дулаацуулдаг байв. Отрын нутагт ирээд машины бүтээлгээр байшин шиг зүйл бариад хэдэн ишгээ хийнэ. Гэртээ орж дулаацчихаад буцаад гарахад зөндөө мал дарагдаад үхчихсэн байдаг байсан. Тэр жил 500 гаруй малаас 200 орчим малтай л үлдсэндээ. Нөхөр маань ч өнгөрч, өрх толгойлж үлдэхэд бүр хэцүү болсон. Малаа маллах, гэр ахуйн ажлаа хийх гээд бүх зүйл толгой дээр ирдэг юм байна. Тухайн үед Улаанбаатар хотод охин маань сургуульд сурч, хүү маань ажилладаг байсан. Ганцаараа мал маллан амьдрахад бэрхтэй болсон учраас хүүгээ авчирч, хамтдаа амьдарч байна. Хэдэн малаа маллан охиныхоо сургалтын төлбөрийг төлдөг...” хэмээн хүүрнэсэн юм.

Манай оронд сүүлийн 70 жилийн хугацаанд 12 удаагийн томоохон зуд тохиолдож нийт 40-50 сая мал хорогджээ. Зудын улмаас үүсэх сөрөг үр дагавар нь нэлээд хожуу малчин өрхийн амьжиргаа, сайн сайхан байдалд нөлөөлж аж. Тухайлбал, зуд болсноос хойш нэлээд хэдэн сарын дараагаас хүмүүсийн орлого багасах, өвчин хууч нь сэдрэх, архгаар өвчлөх, хүүхдээ сургууль завсардуулах зэрэг үр дагаврууд гарч эхэлдэг байна.

“АДАПТ” төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийн улирлын болон урт хугацааны прогнозыг тооцоолох үндэсний чадавхыг нэмэгдүүлэх замаар байгаль цаг уурын гаралтай гамшигт үзэгдлийг болсны дараа нь хариу арга хэмжээ авдаг өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөхөөр ажиллаж байгаа юм. Цаг агаар, уур амьсгалын урьдчилсан прогноз мэдээг эртнээс тооцоолж гаргадаг чадавхтай болсноор уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон төлөвлөлт хийж, тэр хэрээр бэлэн байдлыг хангуулах боломжтой болно. Өөрөөр хэлбэл, цаг агаар, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээ, прогнозыг сайжруулснаар нөлөөллийн цар хүрээг тооцож, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах шийдлүүдэд дүн шинжилгээг бодитой хийх боломж бүрдэж, улмаар хөдөөгийн малчдын хэрэгцээнд бүрэн нийсэн бодлогын шийдвэрүүдийг гаргах боломжтой болох юм. Төслийн хүрээнд хийж байгаа бас нэгэн чухал ажил бол цаг агуур, уур амьсгалын өнөөгийн болон ирээдүйн прогнозад үндэслэж, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг, эрсдэлтэй газруудыг эрэмбэлэн тодорхойлж, тэдгээрийг хамгаалахад орон нутагт дэмжлэг үзүүлж байна. Эмзэг, эрсдэлтэй гэж тогтоогдсон газруудад нутгийн иргэдийн оролцоотойгоор экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, цаг агаарын хатуу ширүүн нөхцөлд, бэлтгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр бий болж буй сөрөг үр дагавруудтай орон нутгийн түвшинд тэмцэх арга зам бол байгаль түшиглэсэн шийдэл бүхий экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх явдал юм. Экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээ нь байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээх замаар хөдөөгийн малчдын байгаль цаг агаарын гаралтай тулгамдсан асуудалтай нүүр тулан тэмцэх, хүнд сорилтуудыг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх бөгөөд ингэснээр тэдний гамшигт үзэгдэлд өргөмтгийн эмзэг байдлыг нь бууруулах болно. Төслийн гол үр дүн нь хөдөөгийн малчдын амьжиргааг дээшлүүлэх тогтвортой шийдэл болсон байгальд суурилсан дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх замаар тэдний чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

— ДОРНОД АЙМАГ —

Малчин И.Отгон-Иш:

ӨВӨЛДӨӨ САЙН БЭЛДСЭН МАЛЧИН ХҮНД АЙХ ЗҮЙЛ БАГА БАЙДАГ



Дорнод аймгийн төлөөлөл 2023 он.

“АДАПТ” төслийн хүрээнд өвлийн бэлтгэлээ базааж тэжээл, дулаан хашаа хороогоо бэлтгэн малын тавлаг байдлыг хангасан малчин өрхөөр шалгарсан Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын малчин И.Отгон-Иштэй хийсэн ярилцлагыг хүргэе.

- Өнөөдөр Монгол орны 90 гаруй хувьд цасан бүрхүүл тогтож, зарим аймгийн нутгаар өвөлжилт хүндэрчихлээ. Мэдээж зөвхөн өвөл гэлтгүй байгаль цаг уурын нөхцөл байдлыг хэрхэн давах нь малчин хүний чадвар, бэлтгэлээ хэр базааснаас шалтгаалдаг. Танай гэр бүлийн хувьд “АДАПТ” төслийн хүрээнд шалгаруулсан өвлийн бэлтгэлээ базааж тэжээл, дулаан хашаа хороогоо бэлтгэн малын тавлаг байдлыг хангасан малчин өрхөөр тодорсон. Мэдээж бэлтгэл сайн байсан байх...

Харин хаа сайгүй л чанга өвөл болж байх шиг байна. Таны хэлдгээр малаа хэрхэн онд оруулах, өвөлжилтийн бэлтгэлээ хангах нь малчин өөрөөс нь шалтгаална. Манай гэр бүлийн хувьд хашаа хороогоо засаж, нүх сүвийг нь бөглөн, хот хороогоо хуурай байлгахын тулд өтөг бууцаа дэвсэж, мөн үхрийн баасаар шаваад малаа оруулахад бэлэн болгодог. Хашаа хороо сайн байх нь мал өнөтэй өвөлжих үндэс болдог учраас өтөг бууцаа ойр ойрхон сольдог. Салхины чигийг сайн тодорхойлж хашаагаа барих хэрэгтэй. Өвөл хашаа барихдаа уулын нөмөр нөөлөгтэй, нарны илч тусдаг,

цас бага унадаг газрыг тооцоолж барих хэрэгтэй юм. Малчид чандмалж буугаад малдаа утаа үнэртүүлэх, нөмөрлөх зэргээр буудаг. Олон жил мал малласан хүний газар зүйн байрлал, ажиглалт, цаг агаарын таамаг чухал шүү. Намар хадлан хадаж, 10 гаруй машин өвс бэлддгээс гадна хивэг, малын уурагт тэжээл худалдан авч өвс, хужир, шүү, жамц давс долоолгохоор хотоос авдаг даа. Мал маллана гэдэг жилийн дөрвөн улирлын ажил шүү дээ. Хавар, зун, намар, өвөл бүхэнд малаа гэсэн сэтгэл зүтгэл байхад мал тарган байдаг. Зундаа туулга, тарилга хийлгэх нь хүртэл малын тарга тэвээрэг, хүч тамираа алдахгүй байхад их тус нэмэр болохоос гадна элдэв шимэгч хорхойноос мал салдаг. Хаврын улиралд мал хатах гээд байдаг учир сайн усалж усан тарга авхуулахыг хичээдэг. Өвөл малын хүчийг

алдуулахгүйн тулд эртнээс малын тэжээл, хужир давсанд оруулчихдаг. Буриадууд өвлийн дулаан өдөрт нь малаа бэлчээрт гаргах, хөлийн чилээг нь гаргаад, ид хүйтэнд бэлчээрт гаргалгүй борддог. Ер нь буриадууд өвөлд сайн бэлдэж хадлан тэжээлийг их авдаг эртний уламжлалтай, үлгэр жишээч зон олон доо.

- Дорнод аймгийн хөрс сул, дээрээс нь хамаг л алдартай гэсэн уяачид адуугаа оруулж, туурайн зуд нүүрэлчихээд байгаа. Бэлчээрийн даац ер нь хэр байгаа вэ?

Бэлчээрийн даац багасаж байгаа ч зөв зохистой ашиглах нь чухал. Өөрөөр хэлбэл сэлгэж ашиглаж сурах хэрэгтэй. Ахмад малчид бусдын өвөлжөө, хаваржааны ойр орчимд малаа бэлчээдэггүй байлаа. Отроор явахдаа малд шимтэй өвс, ургамал, хужир шүүгээ харж бэлчээдэг. Мал нэг таргалчихвал өвлийг өнөтэй давах, хаврыг төлийн хорогдолгүй давах үндэс болдог.

- Өвөлжилт хүндэрч малчид малаа нядалж байна. Гэтэл түүхий эд нь үнэгүй. Энэ талаар малчин хүний хувд ямар бодолтой явдаг бол...

Малын гаралтай түүхий эдийн үнэ тогтмол буурч ирсэн. Тиймээс малчид боловсруулах, бүтээгдэхүүн хийх тал руу явж байна. Түүхий эд, арьс шир боловсруулдаг үйлдвэрүүдийг Улаанбаатар хотод барьчихвал арьс ширний үнэ дээшлэх болов уу. Тэгээд бүтээгдэхүүн хийгээд эхэлбэл сайхан л байна. Малын түүхий эд үнэ цэнгүй хаягдаж буйг хараад харуусч явдаг.



И.Отгон-Иш гэргий Б.Номинцэцэгийн хамт.




GREEN
CLIMATE
FUND



ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр БОАЖЯ, ХХААЯ, НҮБХХ хамтран 2021 оноос хэрэгжүүлж байгаа “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх, эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд Ус Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн судлаачдын баг цаг агаарын аюулын урьдчилсан мэдээнээс нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг гаргах арга зүйг боловсруулж гаргалаа.

Уламжлалт цаг агаарын урьдчилсан мэдээ нь гамшигт үзэгдэл хаана болохыг, нутгийн аль хэсгээр гарч болзошгүйг ерөнхийд нь гаргадаг бол нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ нь тухайн аюулын улмаас хаана, хэн, хэзээ өртөж болзошгүйг нарийвчлан гаргадаг. Энэхүү арга зүйг 2023–2024 оны зудын эрсдэл дээр туршилтын байдлаар гаргасныг дор харуулав.



Завхан аймгийн хувьд зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөв:

Зудын нөлөөллийн урьдчилсан төлөв-Завхан аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар
(а. Зудын эрсдэл/аюул, б. Өвөлжөө, хаваржааны өртөх байдал, в. Малын тоо /хонин толгой/ өртөх байдал)

Зудын эрсдэлийн зурган бүтээгдэхүүн дээр зудын аюул болоход нөлөөлөлд өртөж болзошгүй бүсийн нийгэм-эдийн засгийн мэдээ буюу хүн амын нягтшил, малын тооны мэдээг давхцуулж оруулснаараа болзошгүй аюулд өртөх өртөнгийн хэмжээг харуулсан зудын нөлөөллийн урьдчилсан төлөвийг гаргаад байна.


Уламжлалт зудын эрсдэлийн мэдээгээр /1-р зураг/ 2023 оны 11 сарын 30-ны байдлаар гаргасан “Зудын эрсдэлийн” үнэлгээгээр Завхан аймгийн Тэс, Ургамал сумдын нутаг, Сантмаргац, Завханмандал, Дөрвөлжин, Баянтэс, Тэлмэн, Идэр, Тосонцэнгэл, Их-Уул, Алдархаан, Отгон сумдын зарим газраар “нэн их” эрсдэлтэй, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Яруу, Алдархаан, Цагаанхайрхан, Отгог, Тосонцэнгэл сумдын зарим хэсгээр “дунд зэрэг” эрсдэлтэй бол бусад хэсгээр “их” эрсдэлтэй байх төлөвтэй байна.

Харин **Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвөөр** өвөлжөө болон малын өртөх байдлаар харахад Тэс сумын нутаг, Идэр сумын зүүн хойд хэсэг “маш их” ангилалд, Ургамал, Завханмандал, Сантмаргац, Асгат сумдын нутаг, Баянтэс, Сонгино, Баянхайрхан, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Тосонцэнгэл, Их уул, Алдархаан, Цагаанчулуут, Шилүүстэй сумдын зарим хэсгүүд “их” ангилалд багтаж, бусад хэсгээр “дунд” болон “бага” ангилалд багтах төлөвтэй байна. Малын тоо болон өвөлжөө ихтэй Тэс, Идэр, Ургамал, Завханмандал, Сантмаргац сумдын малчид онцгойлон бэлтгэлтэй байхыг анхааруулж байна. Аймгийн хэмжээнд нийт өвөлжөөний өртөх байдлын хувиар авч үзэхэд өвөлжөөний 2.8%-маш их, 51.1%-их, 36.3%-дунд зэрэг, 9.7%-бага зэрэг өртөх ангилалд байх төлөвтэй. Малын хувьд 6.6%-маш их, 48.4%-их, 35.1%- дунд зэрэг, 9.9%-бага зэрэг өртөх ангилалд багтаж зудад өртөх урьдчилсан төлөвтэй байна.

Нөлөөлөлд суурилсан мэдээгээр зудын эрсдэл болох газар, хүн ам, малын тоог нарийн гаргаж орон нутгийн шийдвэр гаргагчид, ОБЕГ, шуурхай албаныханд хүргэдэг болсноор эрсдэлийн хариу арга хэмжээг шуурхай авах, төлөвлөхөд дөхөмжтэй болно. Нөгөөтгээгүүр, нөлөөлөлд суурилсан зураглал, тайлбараар хэрэв “нэн их” болон “их” эрсдэлтэй бүсэд өвөлжөө хаваржааны байршил нь байгаа тохиолдолд малчид зудыг даван туулах хариу арга хэмжээг бодитойгоор авах, өвөлжилтийн бэлтгэлээ илүү сайн базаах шаардлагатай.


2023-2024 оны зудын нөлөөллийн урьдчилсан мэдээний арга зүйг туршиж үзсэний дүнд 2024 оноос нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвийн зураглалыг бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, ЦУОШГ-аас Монгол орны хэмжээнд нөлөөллийн урьдчилсан мэдээг цаг агаарын аюулын бүх үзэгдэлд гаргахаар төлөвлөн ажиллаж байна. Төслийн зорилгод дөрвөн аймгийн хүрээнд нөлөөлөлд суурилсан зудын эрсдэлийн судалгааг хүргүүлж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ХУВЬД ЗУДЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ



ЗУДЫН ЭРСДЭЛ/АЮУЛ

Завхан аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар



ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ӨРТӨХ БАЙДАЛ

Завхан аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар

Зудын эрсдэлийн зураг

“Зудын эрсдэлийн” 2023 оны 11 сарын 30-ны байдлаар гаргасан үнэлгээгээр Завхан аймгийн Тэс, Ургамал сумдын нутаг, Сантмаргац, Завханмандал, Дөрвөлжин, Баянтэс, Тэлмэн, Идэр, Тосонцэнгэл, Их-Уул, Алдархаан, Отгон сумдын зарим газраар “нэн их” эрсдэлтэй, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Яруу, Алдархаан, Цагаанхайрхан, Отгон

Тосонцэнгэл сумдын зарим хэсгээр “дунд зэрэг” эрсдэлтэй бол бусад хэсгээр “их” эрсдэлтэй байх төлөвтэй байна.

Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөв

Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвийн өвөлжөө болон малын өртөх байдлаар харахад Тэс сумын нутаг, Идэр


сумын зүүн хойд хэсэг “маш их” ангилалд, Ургамал, Завханмандал, Сантмаргац, Асгат сумдын нутаг, Баянтэс, Сонгино, Баянхайрхан, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Тосонцэнгэл, Их уул, Алдархаан, Цагаанчулуут, Шилүүстэй сумдын зарим хэсгүүд “их” ангилалд багтаж, бусад хэсгээр “дунд” болон “бага” ангилалд багтах төлөвтэй байна. Малын тоо болон өвөлжөө ихтэй Тэс, Идэр, Ургамал, Завханмандал, Сантмаргац сумдын малчид онцгойлон бэлтгэлтэй байхыг анхааруулж байна. Аймгийн хэмжээнд нийт өвөлжөөний өртөх байдлын хувиар авч үзэхэд өвөлжөөний 2.8%-маш их, 51.1%-их, 36.3%-дунд зэрэг, 9.7%-бага зэрэг өртөх ангилалд байх төлөвтэй. Малын хувьд 6.6%-маш их, 48.4%-их, 35.1%- дунд зэрэг, 9.9%-бага зэрэг өртөх ангилалд багтаж зудад өртөх урьдчилсан төлөвтэй байна.

Авах арга хэмжээ, төлөвлөлт

МАЛЧИНД ХҮРГЭХ АНХААРУУЛГА:

Аймаг, сумын хэмжээнд энэ жил зудын эрсдэл нэн өндөр, оторлох нөөц нутаг, шаардлагатай хомсдох магадлал их байгаа тул малчин Та дараах арга хэмжээ авч, хохирлоос сэргийлнэ үү. Үүнд:

- Малчид өөрсдийн мал сүргийн тодорхой тооны малыг махалж, борлуулах, хавар борлуулахаар зорилгоор гулуузаар нь хадгалах
- Боломжтой газар отор нүүдэл хийх, гэхдээ туурайн зудаас сэргийлэх
- Гэрээ дулаалах, түлшээ базаах, хашаа хороогоо засаж, сэлбэх, хүнсний хангамж, дулаан хувцсаа бэлтгэх
- Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг алдалгүй сонсож, мал бэлчээхдээ хүн, мал шуурганд дайруулах, цасанд боогдож осолдохоос онцгой сэргийлэх, зам, даваа гүвээ хаагдах байршлыг сайтар мэдэж замд гарч байх
- Өвөлжиж, хаваржих малын 1 хонин толгой дутам хамгийн багадаа доорх хэмжээний хадлан, тэжээлийн нөөц бүрдүүлэх:
 - “Маш их” эрсдэлтэй бүсэд 15 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /Тэс, Идэр, Улиастайн 6-р баг/
 - “Их” эрсдэлтэй бүсэд 13 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний / Ургамал, Завханмандал, Сантмаргац, Асгат сумдын нутаг, Баянтэс, Сонгино, Баянхайрхан, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Тосонцэнгэл, Их уул, Алдархаан, Цагаанчулуут, Шилүүстэй/
 - “Дунд” эрсдэлтэй бүсэд 11 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний / Дөрвөлжин, Яруу, Нөмрөг, Цэцэн-Уул, Баянхайрхан/
 - “Бага” эрсдэлтэй бүсэд 9 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний / Алдархаан, Эрдэнэхайрхан/



МАЛЫН ТОО /ХОНИН ТОЛГОЙ/ ӨРТӨХ БАЙДАЛ
Завхан аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар

АЙМАГ, СУМЫН УДИРДЛАГУУДАД ХҮРГЭХ АНХААРУУЛГА:

Завхан аймгийн хэмжээнд “нэн их болон их” эрсдэлтэй сумд багийн мэдээлэл, өвөлжөөний тоо, малчин өрх, малчны тоог хүснэгтээр гарган аймаг, сумдад хүргүүлнэ. Дараах сэрэмжлүүлэг чиглэл мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

Төсвийн хуваарилалт

- “Нэн их” эрсдэлтэй ангилалд Тэс, Ургамал сумдын нутаг, Сантмаргац, Завханмандал, Дөрвөлжин, Баянтэс, Тэлмэн, Идэр, Тосонцэнгэл, Их-Уул, Алдархаан, Отгон сумдын зарим хэсгээр гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зориулж бусад сумдаас 20 хувь илүү төсөв хуваарилах
- “Их эрсдэлтэй” Дөрвөлжин, Нөмрөг, Идэр, Их-Уул, Цагаанчулуут, Шилүүстэй, Баянтэс, Сонгино, Яруу зэрэг сумдад 10 хувь нэмэгдүүлж төсөв хуваарилах
- “Дунд эрсдэлтэй” үл өөрчлөх /Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Яруу, Алдархаан, Цагаанхайрхан, Отгог, Тосонцэнгэл/ хуваарилалт хийхийг анхаарна уу.


ХОВД АЙМГИЙН ХУВЬД ЗУДЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Зудын эрсдэлийн зураг


2023 оны 11 сарын 30-ны байдлаар гаргасан “Зудын эрсдэлийн” үнэлгээгээр Ховд аймгийн хойд талын сумууд болох Дөргөн, Эрдэнэбүрэн, Мянгад сумдын ихэнх, Буянт,

Чандмань, Манхан, Зэрэг, Мөст, Дарви, Цэцэг, Үенч, Алтай, Булган сумдын зарим хэсгээр зудын эрсдэл “нэн их” эрсдэлтэй байна. Харин Ховд, Дуут, Мөнххайрхан, Цэцэг, Алтай, Булган сумдын ихэнх хэсгээр

“дунд зэргийн” эрсдэлтэй, Үенч, Алтай сумдын зарим хэсгээр “бага” эрсдэлтэй байгаа бол бусад хэсгээр “их” эрсдэлтэй ангилалд багтаж байна.



ЗУДЫН ЭРСДЭЛ/АЮУЛ
Ховд аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар



ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ӨРТӨХ БАЙДАЛ
Ховд аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар

Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөв


Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвийн малын өртөх байдлаар харахад Дөргөн сумын 2-р баг, өвөлжөөний хувьд Жаргалан сумын 12-р баг “маш их” ангилалд багтаж байна. Малын хувьд “дунд” ангилалд Цэцэг, Манхан, Дарви, Мөнххайрхан, Дуут, Ховд, Алтай зэрэг сумдын ихэнх хэсэг, “бага” ангилалд Булган, Үенч, Буянт сумдын зарим газрууд багтсан болон бусад хэсгүүд нь “их” ангилалд багтах урьдчилсан төлөвтэй байна. Харин өвөлжөөний хувьд Мөнххайрхан, Дуут, Манхан, Чандмань, Ховд зэрэг өвөлжөөний тоо ихтэй сумдын ихэнх хэсэг “дунд” гэсэн ангилалд багтах төлөвтэй бол тус аймгийн хойд талын өвөлжөө ихтэй сумдын нутгаар “их” гэсэн ангилалтай байх урьдчилсан төлөвтэй байна. Аймгийн хэмжээнд нийт өвөлжөөний өртөх байдлын хувиар авч үзэхэд өвөлжөөний 38.8%-их, 46.6%-дунд зэрэг, 14.7%-бага зэрэг өртөх ангилалд байх төлөвтэй. Малын хувьд 1.1%-маш их, 56.8%-их, 34.7%- дунд зэрэг, 7.4%-бага зэрэг өртөх ангилалд багтаж удад өртөх урьдчилсан төлөвтэй байна.

Авах арга хэмжээ, төлөвлөлт

МАЛЧИНД ХҮРГЭХ АНХААРУУЛГА:

Аймаг, сумын хэмжээнд энэ жил зудын эрсдэл нэн өндөр, оторлох нөөц нутаг, шаардлагатай хомсдох магадлал их байгаа тул малчин Та дараах арга хэмжээ авч, хохирлоос сэргийлнэ үү. Үүнд:

- Малчид өөрсдийн мал сүргийн тодорхой тооны малыг махалж, борлуулах, хавар борлуулахаар зорилгоор гулуузаар нь



МАЛЫН ТОО /ХОНИН ТОЛГОЙ/ ӨРТӨХ БАЙДАЛ)
Завхан аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар

- хадгалах
- Боломжтой газар отор нүүдэл хийх, гэхдээ туурайн зудаас сэргийлэх
- Гэрээ дулаалах, түлшээ базаах, хашаа хороогоо засаж, сэлбэх, хүнсний хангамж, дулаан хувцсаа бэлтгэх
- Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг алдалгүй сонсож, мал бэлчээхдээ хүн, мал шуурганд дайруулах, цасанд боогдож осолдохоос онцгой сэргийлэх, зам, даваа гүвээ хаагдах байршлыг сайтар мэдэж замд гарч байх
- Өвөлжиж, хаваржих малын 1 хонин толгой дутам хамгийн багадаа доорх хэмжээний хадлан, тэжээлийн нөөц бүрдүүлэх:

- “Маш их” эрсдэлтэй бүсэд 15 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /малын өртөх байдлаар Дөргөн сумын 2-р баг, өвөлжөөний хувьд Жаргалан сумын 12-р баг/
- “Их” эрсдэлтэй бүсэд 13 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний / Эрдэнэбүрэн, Мянгад, Дөргөн, Буянт, Чандмань, Зэрэг, Мөст сумдын ихэнх нутаг, Манхан сумын 4,6-р багууд, Алтай, Дарви сумдын баруун хойд хэсгийн багууд, Булган, Үенч сумдын зүүн хойд хэсгийн багууд, Мөнххайрхан, Ховд сумдын өмнөд хэсгийн багууд/
- “Дунд” эрсдэлтэй бүсэд 11 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /Цэцэг, Дуут сумдын ихэнх нутаг, Алтай, Дарви, Манхан, Чандмань сумдын өмнөд хэсгийн багууд, Мөнххайрхан, Ховд зэрэг сумдын хойд хэсгийн багууд/
- “Бага” эрсдэлтэй бүсэд 9 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /Булган, Үенч сумдын өмнөд хэсгийн багууд, Мөнххайрхан 4-р баг, Дуут 3-р баг, Буянт 5-р баг/

АЙМАГ, СУМЫН УДИРДЛАГУУДАД ХҮРГЭХ АНХААРУУЛГА:

Ховд аймгийн хэмжээнд “нэн их болон их” эрсдэлтэй сумд багийн мэдээлэл, өвөлжөөний тоо, малчин өрх, малчны тоог хүснэгтээр гарган аймаг, сумдад хүргүүлнэ. Дараах сэрэмжлүүлэг чиглэл мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

Төсвийн хуваарилалт

- “Нэн их” эрсдэлтэй Дөргөн, Эрдэнэбүрэн, Мянгад сумдын ихэнх хэсгээр гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зориулж бусад сумдаас 20 хувь илүү төсөв хуваарилах
- “Их эрсдэлтэй” Буянт, Чандмань, Манхан, Зэрэг, Мөст, Дарви сумдын ихэнх, Үенч, Алтай, Булган сумдын зарим хэсгээр 10 хувь нэмэгдүүлж төсөв хуваарилах
- “Дунд эрсдэлтэй” үл өөрчлөх /Ховд, Дуут, Мөнххайрхан, Цэцэг, Алтай, Булган сумдын ихэнх хэсгээр/
- “Бага эрсдэлтэй” сумдад 10-20 хувиар бага төсөв /Үенч, Алтай/ хуваарилахад анхаарна уу.

ДОРНОД АЙМГИЙН ХУВЬД ЗУДЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Зудын эрсдэлийн зураг

2023 оны 11 сарын 30-ны байдлаар гаргасан “Зудын эрсдэлийн” үнэлгээгээр Дорнод аймгийн Матад, Булган сумдын ихэнх хэсгээр, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Сэргэлэн, Чойбалсан, Баянтүмэн сумдын зарим хэсгээр зудын эрсдэл “нэн их” эрсдэлтэй байна. Харин Баяндун, Дашбалбар сумдын ихэнх, Баян-Уул, Цагаан-Овоо, Чулуунхороот сумдын зарим хэсгээр “дунд зэргийн” эрсдэлтэй байгаа бол бусад хэсгээр “их” эрсдэлтэй ангилалд багтах урьдчилсан төлөвтэй байна.


Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөв

Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвийн малын өртөх байдлаар харахад Хэрлэн сумын 11-р баг “маш их” ангилалд, Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Халхгол, Дашбалбар, Матад сумдын зарим газраар “дунд” зэргийн ангилалд, “бага” эрсдэлтэй ангилалд Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо сумдын зарим хэсгээр “бага” гэсэн ангилалд байх бол бусад нутгаар “их”


гэсэн ангилалд өртөх урьдчилсан төлөвтэй байна.

Харин өвөлжөөний хувьд өртөх байдлаар үзэхэд Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын 1-р баг “маш их” ангилалд, “бага” эрсдэлтэй ангилалд Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо сумдын зарим хэсэг багтаж байгаа бол бусад сумдын нутаг нь “их” болон “дунд” зэргийн ангилалд байх урьдчилсан төлөвтэй байна. Тиймээс малчид, иргэд өөрсдийн мал сүргээ зудын эрсдэл багатай бөгөөд мал болон өвөлжөөний өртөх

СҮХБААТАР АЙМГИЙН ХУВЬД ЗУДЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ



ЗУДЫН ЭРСДЭЛ/АЮУЛ
Сүхбаатар аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар



МАЛЫН ТОО /ХОНИН ТОЛГОЙ/ ӨРТӨХ БАЙДАЛ
Сүхбаатар аймгаар, 2023 оны 11 сарын 30-ны байдлаар

Зудын эрсдэлийн зураг

2023 оны 11 сарын 30-ны байдлаар гаргасан “Зудын эрсдэлийн” үнэлгээгээр Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян, Баяндэлгэр, Халзан, Асгат, Сүхбаатар, Наран сумдын нутаг, Мөнххаан, Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын зарим газраар зудын эрсдэл “нэн их” эрсдэлтэй, Түмэнцогт сумын нутаг, Мөнххаан, Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын зарим хэсгээр “их” эрсдэлтэй байх урьдчилсан төлөвтэй байна.

Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөв

Зудын нөлөөлөлд суурилсан урьдчилсан төлөвийн малын өртөх байдлаар харахад Наран сумын баруун хэсэг “маш их” ангилалд, Дарьганга сумын 4-р баг, Эрдэнэцагаан сумын 6-р баг “дунд зэрэг” ангилалд багтаж байгаа бол бусад сумдын нутгаар “их” гэсэн ангилалд багтах урьдчилсан төлөв гарсан байна. Тиймээс малчид, ард иргэд өвөлжилт хүндэрч, зудад өртөх малын тоо их байгааг онцгойлон анхаарна уу. Аймгийн хэмжээнд нийт малын өртөх байдлын хувиар авч үзэхэд нийт малын 2.2%-маш их, 93.3%-их, 4.5%-дунд зэрэг ангилалд багтаж зудад өртөх магадлал нийт аймгаар үзэхэд их гэсэн урьдчилсан төлөвтэй байна.

Авах арга хэмжээ, төлөвлөлт

МАЛЧИНД ХҮРГЭХ АНХААРУУЛГА:

Аймаг, сумын хэмжээнд энэ жил зудын эрсдэл нэн өндөр, оторлох нөөц нутаг, шаардлагатай хомсдох магадлал их байгаа тул малчин Та дараах арга хэмжээ авч, хохирлоос сэргийлнэ үү. Үүнд:

- Малчид өөрсдийн мал сүргийн тодорхой тооны малыг махалж, борлуулах, хавар борлуулахаар зорилгоор гулуузаар нь хадгалах
- Боломжтой газар отор нүүдэл хийх, гэхдээ туурайн зудаас сэргийлэх
- Гэрээ дулаалах, түлшээ базаах, хашаа хороогоо засаж, сэлбэх, хүнсний хангамж, дулаан хувцсаа бэлтгэх
- Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг алдалгүй сонсож, мал бэлчээхдээ хүн, мал шуурганд дайруулах, цасанд боогдож осолдохоос онцгой сэргийлэх, зам, даваа гүвээ хаагдах байршлыг сайтар мэдэж замд гарч байх
- Өвөлжиж, хаваржих малын 1 хонин толгой дутам хамгийн багадаа доорх хэмжээний хадлан, тэжээлийн нөөц бүрдүүлэх:
 - “Маш их” эрсдэлтэй бүсэд 15 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /Наран сумын 1-р баг/
 - “Их” эрсдэлтэй бүсэд 13 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /Түвшинширээ, Уулбаян, Баяндэлгэр,

Халзан, Асгат, Сүхбаатар, Мөнххаан, Онгон, Түмэнцогт сумдын нутаг болон Наран сумын 3-р баг, Эрдэнэцагаан сумын 1,3,4,7,8-р баг, Дарьганга сумын 1,2,3-р багийн нутаг/

- “Дунд” эрсдэлтэй бүсэд 11 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц хэмжээний /Дарьганга сумын 4-р баг, Эрдэнэцагаан сумын 6-р баг/

АЙМАГ, СУМЫН УДИРДЛАГУУДАД ХҮРГЭХ АНХААРУУЛГА:

Сүхбаатар аймгийн хэмжээнд “нэн их болон их” эрсдэлтэй сумд багийн мэдээлэл, өвөлжөөний тоо, малчин өрх, малчны тоог хүснэгтээр гарган аймаг, сумдад хүргүүлнэ. Дараах сэрэмжлүүлэг чиглэл мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

Төсвийн хуваарилалт

- “Нэн их” эрсдэлтэй Түвшинширээ, Уулбаян, Баяндэлгэр, Халзан, Асгат, Сүхбаатар, Наран сумдын нутаг, Мөнххаан, Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын зарим газраар гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зориулж бусад сумдаас 20 хувь илүү төсөв хуваарилах
- “Их эрсдэлтэй” Түмэнцогт сумын нутаг, Мөнххаан, Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын зарим хэсгээр сумдад 10 хувь нэмэгдүүлж төсөв хуваарилалт хийхэд анхаарна уу.



НЭГДСЭН АНХААРУУЛГА

Хадлан, тэжээлийн нөөц бүрдүүлэх

Аймгийн болон сумын өвс, тэжээлийн аюулгүйн фондод тус бүр малын хонин толгой дутам 1.5 кг тэжээл нэгжтэй тэнцэхүйц нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангана уу.

Эмзэг бүлгийг тодорхойлох

Нэн их болон их эрсдэлтэй багууд дахь 200-гаас доош малтай, өрх толгойлсон, эмзэг бүлгийн малчин өрхийн мэдээллийг нэн яаралтай гаргаж, сум, аймаг орон нутгийн түвшинд хүргүүлж, яаралтай тусламжийн арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Нэн их болон их эрсдэлтэй сум, багийн малчид малаа махалж, борлуулах, дараа борлуулахаар гулуузаар нь хадгалах замаар зудын эрсдэлийг хохирол багатай даван туулахад нь дэмжлэг үзүүлнэ үү. Шаардлагатай чиглэлээр тусламж дэмжлэгийг хүсэж, гамшгийн эрсдэлийн яаралтай үед авах арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж ажиллана уу. Цасан шуурга, цасанд боогдох зэрэг цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх зам, даваа гүвээ хаагдах үеийн бэлэн байдлыг хангаж ажиллана уу.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БЭЛЧЭЭРИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ СҮҮЛИЙН 20 ЖИЛД



ХОВД АЙМАГТ

НИЙТ
МАЛЫН ТОО **1,9** ДАХИН
ӨССӨН

НИЙТ
БЭЛЭЭРИЙН **58,7%** ДОРОЙТСОН



СҮХБААТАР АЙМАГТ

НИЙТ
МАЛЫН ТОО **3,9** ДАХИН
ӨССӨН

НИЙТ
БЭЛЭЭРИЙН **43,3%** ДОРОЙТСОН



ЗАВХАН АЙМАГТ

НИЙТ
МАЛЫН ТОО **1,9** ДАХИН
ӨССӨН

НИЙТ
БЭЛЭЭРИЙН **50,8%** ДОРОЙТСОН



ДОРНОД АЙМАГТ

НИЙТ
МАЛЫН ТОО **4** ДАХИН
ӨССӨН

НИЙТ
БЭЛЭЭРИЙН **36,1%** ДОРОЙТСОН